



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

64

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

“Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах
шаардлага, төлбөрийн хэмжээ,
зардлын жишгийг шинэчлэн батлах тухай”

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг нэгдүгээр, Үйл ажиллагааны төлбөрийн хэмжээ, зардлын жишгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай зөвшилцөн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс, ажлын албыг байгуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3 Эрүүл мэндийн тухай хуулийн 15, 40, 41 дүгээр зүйл, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартыг 2013 онд боловсруулан батлуулж, холбогдох стандартыг тусгай зөвшөөрлийн шалгуур үзүүлэлт болгон мөрдүүлэхийг Бодлого хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхбат/-д, орон тооны бус шинжээчдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д. Оюунчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

4 Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Хатанбаатар/-т даалгасугай.

001378

5 Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага, комиссын ажиллах удирдамж, төлбөрийн хэмжээ, зардлын жишиг батлах тухай” 150 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н. УДВАЛ



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
145 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэгт заасан эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хувь хүн, хуулийн этгээд (цаашид "Тусгай зөвшөөрөл хүсэгч" гэх) хүсэлт гаргаж, хуулийн дагуу баримт бичиг бүрдүүлэхэд энэхүү шаардлагыг мөрдлөг болгоно.

1.2 Энэхүү шаардлага нь хуулиар тогтоосон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага (цаашид "Эрх бүхий байгууллага" гэх)-аас томилогдсон ажлын комисс, түүний шинжээчийн баг болон тусгай зөвшөөрөл хүсэгчдэд хамаарна.

1.3 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах (цаашид "Эрүүл мэндийн байгууллага" гэх) хэрэгцээ шаардлага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байна.

1.4 Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэрэгцээний шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох, тусгай зөвшөөрөл олгох гэсэн 2 үе шатаар явагдана.

1.4.1 Тусгай зөвшөөрөл хүсэгч нь эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцсэн төсөл боловсруулж ирүүлнэ.


1.4.2 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах төслийн хэрэгцээ шаардлагад дор дурдсан хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ:

а/ Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлага:

- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй эсэх

*Илрүүлээр хавсралт 1.1 дахь хэсийн
"Хувь хүн" листийг 2013 онд 216р
тушиалдаар хасах*

- Төслийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ижил төрлийн эрүүл мэндийн байгууллага, түүний ашиглалт (ажлын ачаалал)-тай харьцуулах;
- Үйлчлэх хүрээний хүн амын тоо;
- Ядуу эмзэг бүлгийн хүн амд хүрч үйлчлэх байдал.



б/ Санхүү, эдийн засгийн хүчин зүйл:

- Төслийг хэрэгжүүлэх санхүүжилт;
- Төслийн өртөг үйлчлүүлэгчээс авах төлбөрийн хэмжээнд нөлөөлөх байдал;
- Улс, орон нутгийн эрүүл мэндийн талаарх бодлого, стратегид туссан эсэх.

в/ Тусlamж, үйлчилгээнд оруулах хувь нэмэр:

- Удирдлагын болон мэргэжлийн үйл ажиллагааны шилдэг арга барилыг нэвтрүүлэх;
- Нотолгоонд сууринсан дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;
- Олон улсын стандарт, эмнэл зүйн удирдамж, үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлэх;
- Хүний нөөцийн мэргэшсэн байдал;
- Эрүүл мэндийн салбарын өрсөлдөөнд нөлөөлөх байдал.

1.4.3 Тусгай зөвшөөрлийн комиссын эхний шатны хурлаар төслийг хэлэлцэн хэрэгцээ, шаардлага хангасан байгууллагад шинжээчдийг томилох шийдвэрийг гаргана.

1.5 Энэхүү журмын 1.4.3-т заасан шийдвэрийг эрх бүхий байгууллагаас авсны дараа ажлын байрыг бэлтгэх, тусгай зөвшөөрөл авах баримт бичиг бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.

1.6 Тусгай зөвшөөрлийн комиссын 2 дахь шатны хурлаар бүрдүүлсэн баримт бичиг, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлыг тухайн эрхлэх үйл ажиллагааны төрөлд холбогдох Монгол улсын эсвэл олон улсын стандартын шаардлага хангасан барилга байгууламж, ажиллах хүн хүч болон ашиглах техник технологи, тоног төхөөрөмжийн тодорхойлолт, шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг гаргана.

Хоёр. Төслийн баримт бичигт тавигдах шаардлага.

- 2.1 Төсөлд тухайн байгууллагыг байгуулах үндэслэл, хэрэгцээ шаардлага, одоо ажиллаж буй байгууллагуудаас давуу тал, үр ашиг, чанар, мэргэжлийн чадавхийн үзүүлэлт,
- 2.2 Эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлыг тухайн эрхлэх үйл ажиллагааны төрөлд холбогдох стандартын шаардлага хангасан барилга байгууламжийн зураг төсөл, ажиллах хүн хүч болон ашиглах техник технологи, тоног төхөөрөмжийг тодорхойлсон танилцуулга,
- 2.3 Байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх, цаашид бүрэн хүчин чадлаараа тогтвортой ажиллах хүртэлх үйлчлүүлэгчдийн тоон төлөв байдал, нэг эрүүл мэндийн ажилтанд ногдох үйлчлүүлэгчид, үйлчилгээний зардал, төлбөрийн хэмжээ, бүтээгдэхүүний борлуулалтын үнэ, төсвийн төсөөлөл зэргийг гурван жилээр тооцсон санхүүгийн тооцооны танилцуулгыг тусгана.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага

- 3.1 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүсгэн байгуулагчийн талаарх мэдээллийг хүснэгт 1-ийн дагуу гаргана.
- 3.2 Хэд хэдэн хуулийн этгээд, иргэн эрүүл мэндийн байгууллагыг үүсгэн байгуулах тохиолдолд талууд гэрээ байгуулж баталгаажуулсан байна. Гэрээнд үүсгэн байгуулагчийн нийлүүлэх хөрөнгө, эзэмших хувь хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага, бусдад эрх шилжүүлэх, үүсгэн байгуулагчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, эрүүл мэндийн байгууллагыг татан буулгах нөхцлийг тусгана.
- 3.3 Эрүүл мэндийн байгууллага нь дүрэмтэй байна. Дүрэмд Эрүүл мэндийн тухай хуулийн 21.3-т зааснаас гадна байгууллагын нэр, албан ёсны хаяг, үйл ажиллагааны төрлийг тусгана.
- 3.4 Хүний нөөцийн мэдээллийг хүснэгт 2, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ажиллах тохиолдолд Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4, 25.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүснэгт 3-ын дагуу гаргана.

3.5 Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж нь Эрүүл мэндийн тухай хуулийн 19.3.4, 19.3.5-д заасан шаардлагыг хангсан талаарх холбогдох байгууллагын дүгнэлттэй байна. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг хүснэгт 4-ийн дагуу гаргана.

3.6 Тусгай зөвшөөрөл хүсэгч нь тусгай зөвшөөрөл хүссэн үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөж буй стандартын дагуу ажлын байр, хүн хүчин, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэхүү журмын хоёр, гуравт заасан баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр ажлын албанд ирүүлнэ.

4.2 Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичигт эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулан, хуульд заасан баримт бичгийг 2 хувь үйлдэж, эх хувийг Тусгай зөвшөөрлийн комиссын ажлын албанд ирүүлнэ.

4.3 Эрүүл мэндийн дэмжих үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх бол эмнэлгийн тусгай хог хаягдал, ариутгал, халдвартгүйтгэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газартай хийсэн гэрээний эх хувийг хавсаргана.

4.4 Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон тээврийн зардлыг тухайн аж ахуйн нэгж бүрэн хариуцах болно.

*Ингүзээр хавсралтоти 4.4 дах
жэлийн хисэг. (2013 онуу 216р гучлаадар)*

Хүснэгт 1

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Овог нэр	Хүйс	Төрсөн он	Иргэншил	Иргэнний үнэмлэх, түүнийг орлох хувь ёсны баримт бичгийн дугаар	Төгссөн сургууль (он, улс, хотын нэр)	Үндсэн мэргэжил	Одоо эрхэлж буй албан тушаалт	Эрүүл мэндийн байгууллагад хүлээх Үүрэг	Харицах утас, факс, e-мэйл, вэб хуудас
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

Хүснэгт 2

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Эрүүл мэндийн ажилтны овог нэр	Хүйс	Төрсөн он	Төгссөн сургууль ¹ (он, боловсролын зэрэг, цол)	Мэргэжлийн зэрэг	Эмнэлгийн мэргэжилтийн зөвшөөрлийн дугаар	Эрхлэх албан тушаалт, ажил ²	Үндсэн ажилтан эсэх ³	Ажлын туршлага ⁴	Ажилласан жил ⁵
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

Тайлбар:

1. тухайн эрүүл мэндийн ажилтан хэдэн онд, ямар сургуулийг, ямар мэргэжлээр аль улсад төгссөн болохыг боловсролын баримт бичгийг үндэслэн бичиж хавсаргах
2. тусгай зөвшөөрөл хүснэгтийн байгууллагад ямар ажлын байранд ажиллах болохыг тэмдэглэх
3. үндсэн ажилтныг "Ү", гэрээт цагийн ажилтныг "Г" үсээр хүснэгтийн зөрчил үүсэхээргүй бол тухайн бусад байгууллагын удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичээр өгсөн зөвшөөрлийг хавсаргах
4. ямар байгууллагад, ямар албан тушаалд ажиллаж байсан болохыг тухайн эрүүл мэндийн ажилтны нийгмийн даатгалын дэвтрин даятууллагчийн ажил, албан тушаалыг бичиж хавсаргах

70

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАСАН ЖИЛ ГЭХ ОЙЛОХ БА ТУХАЙН МЭРГӨЧИЭР (ТУСГАЙ ЗЕШВЭЕРӨЛ ХУСАГЧИЙН ОЛГОСОН АЖЛЫН БАЙРААДАА АЖИЛЛАХАА

ХУЧНЭГТ 3

ГАДААДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн болон мэндийн ажилтны нэр	Хүйс	Төрсөн он	Монгол улсад хөдөлмөр эрхпэх зөвшөөрөл ¹	Төгссөн сургууль(он, мэргэжил, боловсролын зэрэг, цол)	Мэргэжлийн зэрэг (зөвлөх, тэргүүлэх, ахлах, арга зүйч)	Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн дугаар	Ажлын туршлага	Эрхлэх албан тушаалт ажил	Үндсэн ажилтан эсэх
0	1	2	3	4	5	6	7	8	9	

Тайпбар:

1. Монгол улсад зорчих болон оршин суух талаарх гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын холбогдох зөвшөөрөл болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, дугаар, хүчинтэй хугацааг тэмдэглэж хавсаргах
 2. Бусад баганад орсон асуудлын Маягт №1-ийн дагуу Тэмдэглэх

XvCH3Π 4

ЭМНЭЛГИЙН ТОНГОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НҮҮЧИН ЧАЛАГ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны

145 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний
төлбөрийн хэмжээ

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	
		Олгох	Сунгах
a. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйлчилгээний төлбөр			
1.1	Өрхийн эрүүл мэндийн төв	125500	62750
1.2	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	136600	69000
1.3	Сум дундын эмнэлэг	143000	71500
1.4	Клиник	215000	107500
1.5	Амаржих газар	373000	186500
1.6	Нийгмийн эрүүл мэндийн төв	205000	102500
1.7	Нэгдсэн эмнэлэг	556500	278250
1.8	Сувилал	300000	150 000
1.9	Рашаан сувилал	300000	150 000
1.10	Түргэн тусламжийн төв	210000	105000
1.11	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	710400	355200
1.12	Төв эмнэлэг	855000	427500
1.12	Тусгай мэргэжлийн төв	915000	457500
1.13	Эмчилгээний гоозаслын үйлчилгээ	125800	63000
b. Эм хангамжийн байгууллага			
2.1	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний үйлдвэр	225000	112500
2.2	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллага	122800	61400
2.3	Эмийн сан	124500	62500
c. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протезийн хангамжийн байгууллага			
3.1	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протезийн үйлдвэр	225000	112500
3.2	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протезийн ханган нийлүүлэх	122300	61150
d. Ахуйн шавж мэрэгч усгал, ариутгал халдвартгүйтгэлийн бодисын хангамжийн байгууллага			
4.1	Ахуйн шавж мэрэгч усгал, ариутгал	225000	112500

хоёрдугаар хавсралт 2013 оны 18

216р түүнчлээр журигч болгов.

	халдвартгүйтгэлийн бодисын үйлдвэр		
4.2	Ахуйн шавж мэрэгч устгал, ариутгал халдвартгүйтгэлийн бодисын ханган нийлүүлэх байгууллага	122300	61150
4.3	Ахуйн шавж мэрэгч устгал, ариутгал халдвартгүйтгэлийн үйлчилгээ	123300	61650

Эрүүл мэхдийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний
зардлын жишиг

№	Үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Зардлын жишиг (төгрөг)
1	Баримт бичгийг хянах	1 хуудас	350
2	Ажлын байрны бүтэц, зохион байгуулалтад хяналт, үнэлгээ хийх	1 эмнэлгийн мэргэжилтэн	300
3		1 м2 талбай	10
4		1 тоног төхөөрөмж	500
5		1 арчдас	500
6	Эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх	1 агаар	5000
7		ариун материал	5000
8		хөгц мөөгөнцөр	6000
9		ундны ус/нянгийн тоо, е-ширихиколл, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян/	17000
10	Хяналт үнэлгээний дүнг нэгтгэн танилцуулга (тайлан) бичиж, дүгнэлт гаргах	нэг танилцуулга, дүгнэлт	50000
11	Баримт бичгийн бүрдүүлэлт, ажлын байртай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	1 удаа	30 000
12	Шинжээчийн хөлс	1өдөр	50 000
13	Бүрдүүлэх баримт бичгийн лавлагаа, мэдээллийн хуудас, эмхэтгэл бэлтгэн хэвлүүлэх	1 хэвлэлийн эх	10000
14	Гэрчилгээний зардал	1 ширхэг	6000
15	Комиссын хурлын зардал	1хүн/цаг	8000